



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/122/СТА-ТШЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/28
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох

7515020

бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн төсвийн захирагч Ц.Загдсүмд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.19-нөөс 2019.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль нь "Эх хэл, өв уламжлалаа дээдэлсэн, эвийг эрхэмлэгч, эерэг хандлагатай, эрүүл бие зөв дадалтай, ирээдүйд эзэмших мэргэжлийн чиг баримжаагаа зөв тодорхойлсон хамт олон байх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагчдад боловсрол олгох
- Албан бус боловсрол олгох
- Суралцагчийн онцлог ялгаатай байдлыг харгалзан хичээл бүрийн бэлтгэлийг заах аргын нэгдэл, секцээр чанартай бэлтгэн үр дүнтэй зохион байгуулах
- Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 44 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж, ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэв.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01, цалингийн Payroll” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, 1 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнтэй тул зардлын 1 хувиар сонгов.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1430996,7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 14309,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	3	3.30	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	3.30	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Санхүүгийн тайланд цалингийн зардлыг 7681485 төгрөгөөр дутуу, мөн дүнгээр ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг илүү илэрхийлсэн байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 1276993,0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1276051,7 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь хүүхэд өдрийн ирцээс үдийн цайны зардал, мөн нормын хувцас авах зэрэг зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 76,7 хувьтай байна.

дд	Өмнөх аудитаар илэрсэн зөрчил	Өгөгдсөн зөвлөмж	Хэрэгжилт	Биелэлт
1	Тухайн жилд олгосон цалингийн дүнг сар бүрийн нийгмийн даатгалын мэдээгээрх цалинтай тулган шалгахад 2017 оны 1-р сард Э.Энхбаярт цалин олгоогүй атлаа мэдээгээр 588.8 мянган төгрөгийг мэдээлсэн ба 06-р сард тухайн ажилтны амралтын мөнгө бодогдсоноор зөрүүгүй тохирсон, 11-р сард ЖА-тай байсан ажилтанд өмнөх сарын цалингийн зөрүүнд 49.0 мянган төгрөг олгосон байхад НДХ-т цалин мэдээлээгүй орхигдуулсан байна. Тэтгэвэрт гарсан ажиллагсдын цалингаас 10 хувиар нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцсон атлаа НДХ-т 7.8 хувиар тооцож төлсөн, ажиллагсдын татварын болон нийгмийн даатгалын мэдээгээрх дүн цалингийн дүнтэй тохирохгүй зөрсөн.	Цаашид ажиллагсдын цалинг тухай бүр нь үнэн зөв мэдээлэх, мэдээлэгдээгүй 49.0 мянган төгрөгийн цалинг 2017 оны 01-р сард нөхөн мэдээлэх, 2018 оны эхний улиралд багтаан НДХ-тэй тооцоо нийлж, энэ талаар Төрийн аудитын газар хариу ирүүлэх	НДМэдээг авч үзэхэд 5 сард НДХ-т мэдээлсэн байна.	100%
2	Үдийн цай, томилолтын зардал зэрэг зардлыг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 388 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу зардлыг өглөгийн дансаар дамжуулах	Томилолтын зардлын 390.5 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэж зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.	50%
3	Нярав бараа материалын шаардах хуудсыг өөрөө бичсэн, бараа материалын тайланг сараар гаргаагүй, улирлаар гаргасан. Мөн аж ахуйн материалын 9-р сарын тайлангийн эхний үлдэгдлийг 377.0 мянга, орлогыг 425.0 мянган төгрөгөөр, барилгын засварын материалын тайлангийн орлого, зарлагыг 12-р сард 3417.7 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материалыг 143.0 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдлийг 795.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй гаргасан байна.	Шаардах хуудсыг холбогдох ажилтнаар бичүүлж, нягтлан бодогчоор хянуулан, бараа материалын тайланг сараар гаргах, хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, тооцоо бодсон акт үйлдэж, тооллогын үр дүнг төсвийн захирагчийн тушаалаар баталгаажуулах	НББ-ийн тухай хуулийн 13.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, нярвын тайлангаарх зардлыг тухай бүр санхүүгийн программд оруулаагүй байна.	80%
	Биелэлт хувь		-	76.7

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

2.8.1.1 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

Сургуулийн гал тогоо, тоног төхөөрөмжийг түрээслэгч "Тосуйн гол" ХХК сургуультай байгуулсан гэрээг мөрдөж ажиллаагүй, түрээсийн төлбөрийн 233,383 төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Түрээсийн гэрээний 5.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Оны эхэнд татварын 97975,5 төгрөгийн авлагатай байсныг барагдуулсан ба тайлант оны эцэст 2087194,6 төгрөгийн татварын авлагатай гарсан байхад санхүүгийн тайланд 424047 төгрөгийг авлагаар тусгаж, 1663147,6 төгрөгийн татварын авлагыг тайланд тусгаагүй байна.

Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.8.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант онд цалингаас суутгасан НДШимтгэл 91298009 төгрөг байхад Татварын хэлтэс болон Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлсэн НДШ-ийн дүн 3014342 төгрөгөөр зөрүүтэй буюу 94312351 төгрөг байна. Энэ нь 6 сард багш нарын ээлжийн амралтын цалин олгоходоо НДШ-ийн дээд хязгаарлалтыг тооцож, НДШ-ийг суутгасан атлаа НДХ-т цалинг 6.7.8 саруудад хувааж мэдээлсэнтэй холбоотой байна. Иймд ажил олгогчоос төлсөн НДШ-ийн 1408388 төгрөгийг ажилчдаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсгийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Зарим бараа материалыг зарлагадсан байхад үлдэгдлээр байгаа бөгөөд зарим бараа материалыг программд бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Бараа материалын тооллого, тооцоог чанаргүй хийх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын үлдэгдэлд дахин тооллого хийж, үр дүнг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч, санхүүгийн программд бөөн дүнгээр бүртгэсэн материалыг материал тус бүрээр бүртгэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.2.1 Илрүүлэлт:

Түрээсийн гэрээг аймгийн ИТХ-аас баталсан тогтоолоор тогтоосон тарифийг мөрдөөгүй, баталсан гэрээний загварыг баримтлаагүй, түрээсийн гэрээг холбогдох хүмүүсээр албажуулаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Түрээсийн гэрээг албажуулаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийг мөрдөж, гэрээг аймгийн ОНӨГ-аар албажуулж, түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд тухай бүр дансанд төвлөрүүлж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>63,290,084.38</u>	<u>75,513,462.69</u>
33	АВЛАГА	97,975.54	2,101,175.86
335	Бусад авлага	97,975.54	2,101,175.86
3351	Байгууллагаас авах авлага	97,975.54	2,101,175.86
35	БАРАА МАТЕРИАЛ	63,192,108.84	73,412,286.83
351	Түүхий эд материал	35,146,349.83	37,124,349.83
35110	Тусгай зориулалттай материал	35,146,349.83	37,124,349.83
354	Хангамжийн материал	28,045,759.01	36,287,937.00
35410	Бичиг хэргийн материал	1,145,250.00	1,633,250.00
35420	Аж ахуйн материал	3,615,809.00	3,615,809.00
35440	Түлш, шатах тослох материал	10.01	00.00
35450	Барилгын засварын материал	120,500.00	120,500.00
35470	Бусад хангамжийн материал	23,164,190.00	30,918,378.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,193,272,482.19</u>	<u>2,374,206,750.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,193,272,482.19	2,374,206,750.67
392	Биет хөрөнгө	1,193,272,482.19	2,005,956,750.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,117,195,960.00	1,878,063,070.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-148,997,192.14	-9,083,590.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,620,896.90	259,883,674.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-158,128,900.12	-191,954,396.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	164,092,969.35	170,865,198.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-88,513,109.97	-105,151,508.67
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	194,732.56	194,732.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,259,486.00	20,259,486.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,960,929.19	-17,119,915.27
39217	Ном	43,508,568.80	00.00
393	Биет бус хөрөнгө	00.00	368,250,000.00
39301	Програм хангамж	1,919,860.00	1,919,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,919,860.00	-1,919,860.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	368,250,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,256,562,566.57</u>	<u>2,449,720,213.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>70,050.00</u>	<u>150,180.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	70,050.00	150,180.00
413	Өглөг	70,050.00	150,180.00
4136	Бусад өглөг	70,050.00	150,180.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	12,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	70,050.00	137,780.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,256,492,516.57</u>	<u>2,449,570,033.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,256,492,516.57	2,449,570,033.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,258,784,865.06	1,627,034,865.06
51101	Өмч: - төрийн	1,258,784,865.06	1,627,034,865.06
512	Хуримтлагдсан үр дүн	-2,292,348.49	-77,478,771.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,292,348.49	-2,292,348.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-75,186,422.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	900,013,939.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,256,562,566.57</u>	<u>2,449,720,213.36</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,476,441,107.39	1,355,810,309.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,600,500.00	41,438,555.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,600,500.00	41,438,555.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,600,500.00	41,438,555.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,361,000.00	1,624,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	513,980.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,239,500.00	39,300,575.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	156,573,907.39	37,378,754.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,301,266,700.00	1,276,993,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,280,000.00	22,948,750.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,280,000.00	22,948,750.40
1330	Төсвийн захирагчдаас	132,518,394.39	00.00
133003	Хөрөнгийн	132,518,394.39	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,775,513.00	14,430,004.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	18,775,513.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	14,430,004.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,386,652,167.19	1,430,996,732.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,386,652,167.19	1,430,996,732.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,177,978,453.19	1,328,651,896.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,506,755.33	854,645,210.68
210101	Үндсэн цалин	675,192,355.87	722,245,110.88
210102	Нэмэгдэл	87,786,999.46	87,787,000.00
210104	Урамшуулал	49,527,400.00	44,613,099.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,372,752.00	106,921,615.00
210201	Тэтгэврийн даатгал	91,372,752.00	90,664,409.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,722,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,063,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	12,471,106.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,177,297.00	202,526,762.00
210301	Гэрэл, цахилгаан	5,937,111.00	6,965,996.00
210302	Түлш, халаалт	155,235,600.00	174,066,400.00
210303	Цэвэр, бохир ус	11,004,586.00	21,494,366.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,435,152.00	51,427,549.81
210401	Бичиг хэрэг	5,398,090.00	3,195,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,134,000.00	1,648,010.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,174,742.00	2,173,371.00
210404	Ном, хэвлэл	1,403,800.00	43,618,568.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,324,520.00	792,100.00
2105	Нормативт зардал	392,300.00	347,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	392,300.00	347,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,302,050.00	3,788,500.00
210604	Урсгал засвар	6,302,050.00	3,788,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,617,500.00	782,700.00

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	1,617,500.00	782,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,745,000.00	22,173,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,745,000.00	22,173,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,429,646.86	86,039,189.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,246,800.00	3,252,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	3,117,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,882,846.86	79,669,689.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,673,714.00	102,344,835.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	208,190,713.00	101,385,554.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	18,775,513.00	14,430,004.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,192,000.00	60,374,950.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,380,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	98,897,400.00	26,130,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,945,000.00	450,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	483,001.00	941,281.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	483,001.00	941,281.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	18,000.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	18,000.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	89,788,940.20	-75,186,422.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	89,788,940.20	-75,186,422.99

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,326,985,213.00	1,316,509,734.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,663,000.00	2,137,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,663,000.00	2,137,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,663,000.00	2,137,980.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,663,000.00	1,624,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	513,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,325,322,213.00	1,314,371,754.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,301,266,700.00	1,276,993,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,280,000.00	22,948,750.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,280,000.00	22,948,750.40
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,775,513.00	14,430,004.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	18,775,513.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	14,430,004.00

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,326,985,213.00	1,316,509,734.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,326,985,213.00	1,316,509,734.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,118,311,499.00	1,214,164,899.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,380,698.00	856,682,611.00
210101	Үндсэн цалин	675,066,400.00	724,282,511.00
210102	Нэмэгдэл	87,786,915.00	87,787,000.00
210104	Урамшуулал	49,527,383.00	44,613,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,372,752.00	106,891,615.00
210201	Тэтгэврийн даатгал	91,372,752.00	73,532,615.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	8,339,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	6,671,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,667,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	16,679,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,177,297.00	202,526,762.00
210301	Гэрэл, цахилгаан	5,937,111.00	6,965,996.00
210302	Түлш, халаалт	155,235,600.00	174,066,400.00
210303	Цэвэр, бохир ус	11,004,586.00	21,494,366.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,442,952.00	7,906,061.00
210401	Бичиг хэрэг	3,906,090.00	2,517,470.00
210402	Тээвэр, шатахуун	2,134,000.00	1,648,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,174,742.00	2,173,371.00
210404	Ном, хэвлэл	1,862,600.00	385,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,365,520.00	1,182,220.00
2105	Нормативт зардал	2,282,750.00	347,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	392,300.00	347,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,890,450.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,403,750.00	3,788,500.00
210604	Урсгал засвар	4,403,750.00	3,788,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,617,500.00	782,700.00
210702	Дотоод албан томилолт	1,617,500.00	782,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,745,000.00	22,287,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,745,000.00	22,287,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,888,800.00	12,951,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,537,800.00	7,291,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	351,000.00	5,660,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,673,714.00	102,344,835.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	208,190,713.00	101,385,554.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	18,775,513.00	14,430,004.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,192,000.00	60,374,950.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,380,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	98,897,400.00	26,130,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,945,000.00	450,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	483,001.00	941,281.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	483,001.00	941,281.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	18,000.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	18,000.40

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,258,784,865.06	00.00	-92,081,288.69	1,166,703,576.37
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,258,784,865.06	00.00	-92,081,288.69	1,166,703,576.37
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	89,788,940.20	89,788,940.20
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,258,784,865.06	00.00	-2,292,348.49	1,256,492,516.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,258,784,865.06	00.00	-2,292,348.49	1,256,492,516.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	900,013,939.78	00.00	900,013,939.78
Тайлант үеийн үр дүн	368,250,000.00	00.00	-75,186,422.99	293,063,577.01
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-77,478,771.48	2,449,570,033.36

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,303,047,000.00	1,302,446,699.00	1,278,617,000.00	1,277,675,719.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,303,047,000.00	1,302,446,699.00	1,278,617,000.00	1,277,675,719.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,113,608,400.00	1,113,031,499.00	1,191,022,700.00	1,190,720,169.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,466,500.00	812,380,698.00	848,647,200.00	856,298,631.00
Үндсэн цалин	00.00	00.00	716,247,100.00	723,898,531.00
Нэмэгдэл	00.00	00.00	87,787,000.00	87,787,000.00
Урамшуулал	00.00	00.00	44,613,100.00	44,613,100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,501,500.00	91,372,752.00	114,573,200.00	106,891,615.00
Тэтгэврийн даатгал	91,501,500.00	91,372,752.00	114,573,200.00	73,562,615.00
Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	00.00	8,339,400.00
ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	00.00	6,671,900.00
Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	00.00	1,667,900.00
Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	00.00	16,679,800.00

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,259,800.00	172,177,297.00	202,526,800.00	202,526,762.00
Гэрэл, цахилгаан	6,004,200.00	5,937,111.00	7,104,200.00	6,965,996.00
Түлш, халаалт	155,255,600.00	155,235,600.00	174,006,400.00	174,066,400.00
Цэвэр, бохир ус	11,000,000.00	11,004,586.00	21,416,200.00	21,494,366.00
Хангамж, бараа материалын зардал	13,458,200.00	13,442,952.00	8,043,100.00	7,906,061.00
Бичиг хэрэг	2,403,200.00	3,906,090.00	3,152,300.00	2,517,470.00
Тээвэр, шатахуун	2,147,900.00	2,134,000.00	1,648,000.00	1,648,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,855,700.00	2,174,742.00	1,000,800.00	2,173,371.00
Ном, хэвлэл	2,091,200.00	1,862,600.00	1,258,300.00	385,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,960,200.00	3,365,520.00	983,700.00	1,182,220.00
Нормативт зардал	2,297,400.00	2,282,750.00	468,300.00	347,000.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	406,900.00	392,300.00	165,600.00	347,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,890,500.00	1,890,450.00	302,700.00	00.00
Эд хогшил, урсгал засварын зардал	4,458,500.00	4,403,750.00	3,788,900.00	3,788,500.00
Урсгал засвар	4,458,500.00	4,403,750.00	3,788,900.00	3,788,500.00
Томилолт, зочны зардал	1,725,000.00	1,617,500.00	783,600.00	782,700.00
Дотоод албан томилолт	1,725,000.00	1,617,500.00	783,600.00	782,700.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,749,500.00	1,745,000.00	712,100.00	677,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,749,500.00	1,745,000.00	712,100.00	677,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	13692000.00	13608800.00	11479500.00	11471900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	13,292,000.00	13,257,800.00	5,979,500.00	5,971,900.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	351,000.00	5,500,000.00	5,500,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	189438600.00	189415200.00	87594300.00	86955550.00
Бусад урсгал шилжүүлэг	189,438,600.00	189,415,200.00	87,594,300.00	86,955,550.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,199,200.00	58,192,000.00	60,954,400.00	60,374,950.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,380,800.00	2,380,800.00	00.00	00.00
Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	98,897,400.00	98,897,400.00	26,130,600.00	26,130,600.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,961,200.00	29,945,000.00	509,300.00	450,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,303,047,000.00	1,302,446,699.00	1,278,617,000.00	1,277,675,719.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,301,423,000.00	1,300,783,699.00	1,276,993,000.00	1,276,051,719.00

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,301,423,000.00	1,300,783,699.00	1,276,993,000.00	1,276,051,719.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,624,000.00	1,663,000.00	1,624,000.00	1,624,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,624,000.00	1,663,000.00	1,624,000.00	1,624,000.00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	01.00	01.00
Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	97.00	99.00	100.00	99.00
Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
Гүйцэтгэх ажилтан	69.00	71.00	72.00	71.00
Үйлчлэх ажилтан	27.00	27.00	27.00	27.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	97.00	99.00	100.00	99.00
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	79.00	78.00	79.00	78.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18.00	21.00	21.00	21.00